

Эдийн засаг, хөгжлийн яамны
Төрийн нарийн бичгийн даргын 2026 оны
01 дүгээр сарын 13-ний өдрийн 1/104 дугаар
тушаалын долоодугаар хавсралт

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

А. ТАНИЛЦУУЛГА

1. Гэрээний дугаар:	2. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: Эдийн засаг, хөгжлийн яам
3. Орон тоо, албан тушаал: Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан дэд зохицуулагч	
4. Ажлын байрны шууд харьяалах удирдах албан тушаалын нэр: Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн зохицуулагч	

Б.ЧИГ ҮҮРЭГ

1. Ажлын байрны үндсэн зорилго:	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн хүрээнд мал аж ахуй, бэлчээрийн менежменттэй холбоотой бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллах.	
2. Ажлын байрны зорилтууд:	4. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Төслийн зохицуулагчийн удирдлагад ажиллаж, салбар, дэд төсөл, техникийн чиглэлээр гүйцэтгэлийн ажлыг хариуцах; 5. Төслийг Монгол Улсын Засгийн газар болон Хөгжлийн түншүүдийн бодлого, удирдамж, зааварт нийцүүлэн хэрэгжүүлэх; 6. Төслийн мал аж ахуй, бэлчээрийн менежментийн бүрэлдэхүүний хүрээнд хамтын ажиллагааг удирдан зохион байгуулж, тавьсан зорилт, арга хэмжээг зорилтот аймаг, сумдад үр дүнтэй хэрэгжүүлэх.	
3. Ажлын байрны үндсэн үйл ажиллагаа:	Хугацаа, хуваарь	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт
23. Төслийн дэд бүрэлдэхүүн хэсэг, салбарын үйл ажиллагааг төлөвлөх, хянах, уялдуулах; 24. Төслийн гүйцэтгэл, тайлан, техникийн баримт бичгийг боловсруулахад мэргэжлийн дэмжлэг үзүүлэх; 25. Хэлтэс, мэргэжилтнүүдийн өдөр тутмын ажлыг зохион байгуулах, үр дүнг дүгнэх; 26. Зохицуулагчийн үүргийг эзгүйд орлон гүйцэтгэх, дотоод хяналт тавих; 27. Салбар хоорондын мэдээлэл солилцоо, төслийн уялдаа холбоог хангахад дэмжлэг үзүүлэх;	Төсөл хэрэгжих хугацаанд	Үйл ажиллагааны явцын тайлан, сар, улирал, жилийн тайлан

28. Төслийн зөвлөхүүд, холбогдох төрийн байгууллагууд, төслийн удирдах хороо, Хөгжлийн түншүүд болон бусад хандивлагч, төслийн бусад оролцогч талуудын уялдаа холбоог хангах; 29. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй гэрээ, хэлэлцээрийн дагуу үйл ажиллагааны хуваарь гаргах, зөвлөгөө өгөх; 30. Шаардлагатай үед багийн гишүүдэд техникийн зааварчилгаа өгч, зөвлөхүүдээс санал, зөвлөмж авах ажлыг зохицуулах; 31. Хөгжлийн түншүүдийн тайлагналын шаардлагын дагуу шаардлагатай тайланг цаг тухайд нь бэлтгэх, мэдээлэл цуглуулах процесст хяналт тавих; 32. Төслийн хэрэгжилтийг Хөгжлийн түнш байгууллагуудын Хамгааллын бодлогын баримт бичиг болон Худалдан авах ажиллагааны удирдамж, Зөвлөхүүдийн ашиглах заавар, Авлигатай тэмцэх бодлого зэрэг удирдамж, бодлого, түүнчлэн зохих хяналт, зээлийн баталгаа зэрэгт нийцүүлэн хэрэгжүүлэх бодлогын тайлан болон Худалдан авах ажиллагааны удирдамж, Зөвлөхүүдэд зориулсан удирдамж, Авлигатай тэмцэх бодлого зэрэг удирдамжууд, мөн бодлого, түүнчлэн зохих шалгалт, зээлийн баталгаа, төсөл болон хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн батлагдсан гэрээний дагуу төсөл хэрэгжүүлэх; 33. Менежментийн мэдээллийн систем (MIS) - ийг нэвтрүүлэх замаар төслийн удирдлагын тогтолцоог бий болгох, үүнд тогтмол мэдээлэл оруулах дотоод журам, гүйцэтгэгч болон хэрэгжүүлэгч байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох, мөн НТХН-д төслийн гүйцэтгэлийн удирдлагын систем (PPMS), худалдан авалт, зарцуулалт, санхүүгийн удирдлага үүнд дотоод болон гадаад аудит, төслийн явц, хамгааллын арга хэмжээний талаар тайлагнах; 34. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан сургалт, зөвлөгөөн, танилцах аялал, чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа, мал аж ахуй, бэлчээрийн менежментийн сайн туршлага, үйл ажиллагааг бэлтгэх, хэрэгжүүлэх, хяналт тавих;		
--	--	--

35. Төслийн бүх үе шатны төлөвлөлт, хэрэгжилт, хяналтын түвшний бүх үйл ажиллагаанд зохицуулалт, хяналтын үүрэгтэй оролцох;		
36. Төслийн зардал, төлөвлөлтөд хяналт тавьж, дүн шинжилгээ хийж, болзошгүй зээлийн хэмнэлт, дутагдал, саатлыг аль болох эрт илрүүлэх;		
37. Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн зохицуулагчийн өгсөн төсөлтэй холбоотой бусад үүрэг даалгавар, үйл ажиллагааг гүйцэтгэх.		
38. Малчдын зохион байгуулалтын бүтэц болох бүлэг, хоршоод байгуулах;	Төсөл хэрэгжих хугацаанд	Үйл ажиллагааны явцын тайлан, сар, улирал, жилийн тайлан
39. Хамтын оролцоотой бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулах;		
40. Мал эмнэлгийн гэрчилгээжүүлэлт, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мөшгөх тогтолцоог сайжруулах;		
41. Мал эмнэлгийн лаборатори, бүсийн судалгаа, шинжилгээний төв байгуулах;		
42. Мал эмнэлгийн хяналтын цэг, мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бүс байгуулах;		
43. Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаагаар дамжуулан малчдын бүлэг, хоршоодын жижиг төслүүдэд хөрөнгө оруулалт хийх;		
44. Тариалангийн болон малын тэжээлийн зориулалттай талбайн усалгааны систем, уст цэг, хамгаалах байгууламжийг бий болгох.		
Тайлбар: Ажил гүйцэтгэх хугацаа, хуваарийг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр тодорхойлно.		

В. АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

1.Ажлын байранд тавигдах шаардлага	1.1.Ерөнхий шаардлага	Үзүүлэлт	Чухал шаардлагатай	Шаардлагатай
		Боловсрол	Магистр болон түүнээс дээш боловсролын зэрэг хамгаалсан.	
		Мэргэжил	Газар тариалан ба мал аж ахуй /0811/,	Төсөлд хамаарах бусад техникийн чиглэлийн мэргэжилтэй.

		Туршлага	Хөдөө аж ахуй, нийтийн удирдлага, бүс нутгийн хөгжлийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан.	Олон улсын байгууллагын төсөлд ажилласан.
		Ур чадвар	- Англи, монгол хэлний бичгийн болон ярианы ахисан түвшний мэдлэгтэй, - Асуудал шийдвэрлэх, манлайлах, үр дүнтэй хамтын ажиллагаа өрнүүлэх ур чадвартай.	Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулж байсан.
	1.2.Тусгай шаардлага	-Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн талаар ойлголттой байх, -Орон нутагт томилолтоор ажиллах боломжтой байх.		

Г. АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ	
Шийдвэрийн огноо: 2026.01.13	
Дугаар: А/04	
(тамга/ тэмдэг)	
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	(И.БАТХҮҮ)
2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр	

